

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.10.13

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Инфляц улсын хэмжээнд 9%-д хүрч өслөө
- “Стэйблкойн”-ийг үндэсний төлбөрийн хэрэгсэл болгох боломжийг судлана
- “Чингис Хаан” хөрөнгийн сангаараа дамжуулан дата төвийн салбарт хөрөнгө оруулна
- Компаниудын 3-р улирлын тайлан зарлагдаж эхэлнэ

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.63%	1.93%	25.47%
MSE A	0.13%	7.58%	20.27%
MSE B	0.68%	0.2%	34.89%

2025/10/06 – 2025/10/10

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
MLG	833,846,577.82
ERDN	754,103,000.00
KHAN	405,140,325.00
GLMT	160,702,621.00
MSE	141,853,416.22

2025/10/06 – 2025/10/10

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
HSG	24,000.00	32.09%
BAN	1,920.00	20.00%
HRM	198.00	15.10%
EER	4,600.00	15.00%
TAND	22.75	13.75%

2025/10/06 – 2025/10/10

2025 он 10-р сарын 13

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,270

ТОП-20 индекс

49,561

MSE A

19,153

MSE B

14,440



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - II улирал

Инфляц

9.0%

2025-09 сар

ГВУН(сая\$)

5,874.52

2025-09 сар

Бодлогын
хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.6%

USD/MNT

3,593.70

2025-10-12



Эдийн засгийн мэдээлэл

ИНФЛЯЦ УЛСЫН ХЭМЖЭЭНД 9%-Д ХҮРЧ ӨСЛӨӨ

2025 оны 9-р сард Монгол Улсын хэмжээнд хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 9.0 хувиар, өмнөх сараас 0.2 хувиар өссөн нь инфляцын түвшин тогтвортой өндөр хэвээр байгааг харуулж байна. Үнийн өсөлтөд дотоодын болон импортын барааны өртгийн нэмэгдэл зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлжээ.

Нийт инфляцын 9.0 хувийн өсөлтөд бензин, түлшнээс бусад импортын барааны үнийн өсөлт 2.2 нэгж хувь буюу 24.9 хувийн нөлөө үзүүлсэн бол, мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнийн өсөлт 5.3 нэгж хувь буюу 59.0 хувийн нөлөөтэй байв. Энэ нь дотоодын зах зээл дэх бараа, үйлчилгээний өртөг өсөлт нь нийт инфляцын гол хөдөлгөгч хүчин зүйл болж байгааг илтгэнэ.

Монголбанкны зүгээс инфляцын талаар баримтлах бодлогыг боловсруулсан билээ. Үүнд:

Өмнөх жилүүдэд цалин, цахилгаан, нийтийн тээвэр зэрэг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ өссөн нь инфляцыг 2025 оны эхний хагаст зорилтоос давуулах гол хүчин зүйл болсон. Гэвч мөнгөний болон төсвийн бодлого шат дараатайгаар чангарах, улирлын шинжтэй үнийн өсөлт намжих, эрэлт харьцангуй тогтворжих зэрэг нөлөөгөөр жилийн сүүлчээс инфляц буурах хандлагатай болж байна.

Хэрэв гадаад орчны ноцтой шок (жишээ нь, шатахуун, хүнсний дэлхийн үнийн огцом өсөлт) үүсэхгүй, төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийг дахин нэмэхгүй бол инфляц буурах чиг хандлага үргэлжилж, 2025 оны эцэст зорилтот түвшинд хүрч тогтворжих төлөвтэй байна.

"СТЭЙБЛКОЙН"-ИЙГ ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ БОЛГОХ БОЛОМЖИЙГ СУДЛАНА

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлд үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчин, зохицуулалтыг боловсронгуй болгохоор зорьж байна. Мөн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, "Стэйблкойн"-ийг төлбөрийн хэрэгсэл болгох боломжийг судалж, олон улсын зарчмын дагуу хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхээр болжээ. Энэ нь манай улсын санхүүгийн салбарт томоохон өөрчлөлт авчирч магадгүй юм!

МОНГОЛ УЛС ДАТА ТӨВИЙН САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛНА

Монгол Улс уул уурхайгаас хамаарсан эдийн засгаа төрөлжүүлэх зорилгоор сэргээгдэх эрчим хүчээр ажиллах дата төвүүд байгуулах, үүнийг анхны "Чингис Хаан" хөрөнгийн сангаараа дамжуулан санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Тус сангийн гүйцэтгэх захирал Б.Тэмүүлэн Сингапурт болсон Milken Institute Asia Summit-ийн үеэр CNBC-д өгсөн ярилцлагадаа "Манай улсад дата төв байрлуулахад тохиромжтой уудам газар нутаг, сэрүүн уур амьсгал бий" хэмээн онцолжээ. "Чингис Хаан" хөрөнгийн сан 2024 оны 4 дүгээр сард хууль ёсоор байгуулагдсан бөгөөд 1.4 тэрбум ам.долларын хөрөнгөтэй юм. Ази тивийн орнуудаас Япон, Сингапур, Малайз зэрэг улс дата төвийн хүчин чадлаа эрчимтэй нэмэгдүүлж байгаа бөгөөд хиймэл оюун ухааны өсөн нэмэгдэж буй хэрэглээ нь асар их тооцоолол, цахилгаан, хөргөлт, сүлжээний дэд бүтцийг шаарддаг. Goldman Sachs-ийн тооцоогоор дата төвийн цахилгааны хэрэглээ 2027 он гэхэд 50 хувиар, 2030 он гэхэд 165 хувиар өсөх төлөвтэй байна.



Зах зээлийн мэдээлэл

ТОП-20 ИНДЕКСИЙН ГҮЙЦЭТГЭЛ ДАХИН СЭРГЭЛЭЭ

График 1. ТОП-20 индексийн ханшийн өөрчлөлт




Дэмжлэгийн бүс

ТОП-20 индекс 2025 он гарснаар 6.23 хувиар унаад байна. Компаниудын орлого эхний хагас жилд өссөн ч гэсэн цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байлаа. Ханш 46,300 түвшин рүү үргэлжлэн унах магадлал өндөр бөгөөд 46,300 хүчтэй дэмжлэгийн бүс болж байна. Энэ оны сүүлийн улиралд индекс хүчтэй өсөх магадлалай.


ЭНЭ ДОЛОО ХОНОГООС ЭХЛЭН КОМПАНИУДЫН 3-Р УЛИРЛЫН ТАЙЛАН ЗАРЛАГДАНА

График 2. GLMT хувьцааны ханшийн өөрчлөлт



ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

ВАЛЮТЫН ХАНШИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хэрэв нүүрсний үнэ 10%-иар буурч экспортын орлого 800 сая ам.доллараар багасна гэж үзвэл: 2026 онд инфляц 0.7 нэгж хувиар нэмэгдэхтэй уялдан төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3-5% орчим сулрах магадлалтай.

График 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

